



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/01/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarijargalo@audit.gov.mn](mailto:amarijargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Товчилсон үгийн жагсаалт .....	3
Хүснэгтийн жагсаалт .....	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	15
3.4.2 Авлага.....	15
3.4.3 Бараа материал.....	16
3.4.4 Үндсэн хөрөнгө.....	16
3.4.5 Өр төлбөр.....	17
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо .....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	18
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	18
3.5.3 Нэмэлт төсөв .....	19
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн .....	19
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	20
4.1 Ерөнхий зүйл .....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	22
5.1 Залруулсан алдаа .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.2 Албан шаардлага .....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	23

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

## **Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт .....	14
Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.....	15
Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл .....	15
Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл .....	16
Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл .....	16
Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл.....	17
Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо.....	17
Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	18
Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт .....	19
Хүснэгт 10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	21

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 4/225  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Д.БАТСУУРЬ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Алтанбулаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг 88,7 хувиар, 2023 оны сумын хөгжлийн төлөвлөгөөг 80,3 хувиар хэрэгжүүлсэн дүнтэй байна.

#### Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тайлант онд сумын бүх төсөвт байгууллагууд, аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээний салбарууд болон нийтийн эзэмшлийн талбай, 4 замын уулзварууд, төвлөрсөн хогийн цэгийг бүрэн камержуулсан 6,249.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажилд 71,738.2 мянган төгрөг, хүүхдийн тоглоомын талбай, явган зам тохижилтод 154,451.0 мянган төгрөгөөр нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж

үзлээ. Тус санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,402,716.56	1,389,548.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а 3б	559,759.77	950,120.71
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	714,500.52	291,843.34
34	УРЬДЧИЛГАА	8а, 8б, 8в	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	9а	128,456.28	147,584.78
36	НӨӨЦИЙН БАРАА		-	-
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	12а, 12б, 12в	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		10,030,542.01	9,284,891.66
39200	Биет хөрөнгө		9,974,434.01	9,224,723.66
39300	Биет бус хөрөнгө		56,108.00	60,168.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>11,433,258.58</b>	<b>10,674,440.49</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		958.47	254.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	958.47	254.60
41300	Өглөг	17а, 17б	958.47	254.60
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,432,300.11	10,674,185.89
51	Засгийн газрын хувь оролцоо		11,432,300.11	10,674,185.89
51100	Засгийн газрын оруулсан капитал		735,484.95	735,484.95
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		735,484.95	735,484.95
51200	Хуримтлагдсан үр дүн		10,315,255.01	9,557,140.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		381,560.15	381,560.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>11,433,258.58</b>	<b>10,674,440.49</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,517,579.99</b>	<b>2,641,663.60</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,074,769.70	1,508,792.47
110	Орлогын албан татвар	673,855.84	969,168.11
1100	Хувь хүний орлогын албан татвар	693,661.35	990,168.11
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(19,805.51)	(21,000.00)
113	Хөрөнгийн албан татвар	131,055.96	130,650.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	269,857.91	408,974.16
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	178,163.04	162,282.15
1181	Газрын төлбөр	33,378.75	29,950.21
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	58,316.12	216,741.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	494,253.64	544,208.67
120	Нийтлэг татварын бус орлого	494,253.64	482,402.77
122	Тусламжийн орлого	-	61,805.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,948,556.64	588,662.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	253,990.20	424,751.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,131.49	78,384.95
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,364,434.95	85,526.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,791,221.78</b>	<b>3,397,155.12</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,577,848.65	2,527,227.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,274,001.08	2,515,377.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	360,235.06	538,783.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,459.99	66,690.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	400,448.02	75,657.45
2104	Хангамж, бараа материалын зардал	40,704.48	47,801.27
2105	Нормативт зардал	-	860.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,526.50	3,369.66
2107	Томилот, зочны зардал	4,654.90	5,076.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,016.16	8,603.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,380,955.99	1,768,535.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,303,847.57	11,849.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,225.50	7,095.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,239,622.07	4,754.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	213,373.13	869,927.38
2200	Дотоод эх үүсвэрээр	213,373.13	869,927.38
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(273,641.79)	(755,491.52)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,339,299.48	2,622.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(4,612,941.27)	(758,114.22)

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,272,273.65	2,369,177.56
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,074,769.70	1,508,792.47
110	Орлогын албан татвар	673,855.84	969,168.11
1100	Хувь хүний орлогын албан татвар	693,661.35	990,168.11
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(19,805.51)	(21,000.00)
113	Хөрөнгийн албан татвар	131,055.96	130,650.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	269,857.91	408,974.16
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	178,163.04	162,282.15
1181	Газрын төлбөр	33,378.75	29,950.21
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	58,316.12	216,741.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	248,947.30	271,722.63
120	Нийтлэг татварын бус орлого	248,947.30	209,916.73
122	Тусламжийн орлого	-	61,805.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,948,556.64	588,662.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	253,990.20	424,751.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,131.49	78,384.95
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,364,434.95	85,526.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,492,176.74	1,333,527.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,492,176.74	1,333,527.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,161,262.83	1,313,488.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,876.57	536,946.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,590.91	67,900.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	400,514.02	75,657.45
2104	Хангамж, бараа материалын зардал	70,469.65	91,078.00
2105	Нормативт зардал	-	1,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,672.70	3,599.66
2107	Томилт, зочны зардал	3,281.30	4,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,827.06	14,411.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,030.63	517,694.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,330,913.91	20,039.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,183.70	15,285.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,239,622.07	4,754.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,108.14	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	780,096.91	1,035,649.68

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	555,311.11	548,790.04
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	555,311.11	548,790.04
2200	Дотоод эх үүсвэрээр	555,311.11	548,790.04
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(555,311.11)	(548,790.04)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(163,623.82)	(96,498.70)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	163,623.82	96,498.70
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	61,161.99	390,360.95
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	498,597.78	559,759.77
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	559,759.77	950,120.71

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,731,046.97	2,341,685.63	12,025,073.88	16,097,806.48
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(995,562.02)	(1,960,125.48)	2,903,122.40	(52,565.10)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,484.95	381,560.15	14,928,196.29	16,045,241.39
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,612,941.27)	(4,612,941.27)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,484.95	381,560.15	10,315,255.01	11,432,300.11
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	735,484.95	381,560.15	10,315,255.01	11,432,300.11
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735484.9483	381560.1519	10315255.01	11432300.11
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-758,114,221.90	-758,114,221.90
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	735,484.95	381,560.15	9,557,140.79	10,674,185.89

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,233,505.60</b>	<b>1,786,712.41</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,290,647.90	1,247,378.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,288,047.90	1,244,778.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	510,230.20	501,945.91
210101	Үндсэн цалин	418,628.40	326,050.70
210102	Нэмэгдэл	91,601.80	115,234.60
210104	Урамшуулал	-	59,043.14
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,617.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,778.70	63,584.09
210201	Тэтгэврийн даатгал	43,369.60	43,234.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,102.30	5,088.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,081.90	4,071.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020.40	1,011.18
210205	Эрүүл мэндийн даатгал	10,204.50	10,177.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	527,151.30	497,510.89
210301	Гэрэл, цахилгаан	47,897.30	52,322.70
210302	Түлш, халаалт	469,229.00	435,028.19
210303	Цэвэр, бохир ус	10,025.00	10,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,462.00	39,416.55
210401	Бичиг хэрэг	3,275.10	3,457.50
210402	Тээвэр, шатахуун	16,655.10	17,200.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,831.80	3,103.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,700.00	15,655.20
2105	Нормативт зардал	1,300.00	1,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300.00	1,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,100.00	8,099.66
210604	Урсгал засвар	8,100.00	8,099.66
2107	Томилолт, зочны зардал	6,275.10	4,900.00
210702	Дотоод албан томилолт	6,275.10	4,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,520.00	16,863.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,300.00	14,988.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,040.00	1,032.00
210803	Даатгалын үйлчилгээ	500.00	318.38
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400.00	378.64
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	280.00	145.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,230.60	111,158.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	117,830.60	108,758.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400.00	2,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,600.00	2,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,600.00	2,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600.00	2,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	742,857.70	442,835.22
220001	Барилга байгууламж	448,857.70	379,067.04
222001	Тоног төхөөрөмж	125,000.00	25,338.16
223001	Бусад хөрөнгө	169,000.00	38,430.02
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.00	96,498.70
230001	Эргэж төлөгдөх зээл	200,000.00	96,498.70
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,233,505.60</b>	<b>2,023,695.45</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	435,657.70	424,751.50
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	435,657.70	424,751.50
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,369,147.90	1,415,055.29
320001	Орон нутгийн төсвөөс	1,369,147.90	1,415,055.29
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	330,700.00	122,082.76
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	122,082.76
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	130,700.00	-
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	98,000.00	61,805.90
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	98,000.00	61,805.90

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 он	2023 он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>332,098.43</b>	<b>118,715.77</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,098.43	94,170.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194,244.07	73,933.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	35,000.86
210101	Үндсэн цалин	0.00	4,036.24
210102	Нэмэгдэл	0.00	30,267.70
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	696.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	4,316.06
210201	Тэтгэврийн даатгал	0.00	2,939.12
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	344.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	275.39
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	68.85
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	688.47
2104	Хангамж, бараа материалын зардал	3,281.40	3,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,281.40	3,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,147.00	1,300.00
210604	Урсгал засвар	1,147.00	1,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,494.36	1,273.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,494.36	1,273.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,321.32	29,042.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,321.32	29,042.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,854.36	20,237.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,556.60	12,685.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	95,556.60	12,685.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,297.76	7,552.33
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	40,330.82	2,797.52
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,966.94	4,754.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	24,545.26
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	24,545.26
223001	Бусад хөрөнгө	0.00	24,545.26
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>330,131.49</b>	<b>118,715.77</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,131.49	118,715.77
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	271,324.94	70,969.35
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,806.56	47,746.42

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Иргэдийн аятай тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн компани 100%-ийн хөрөнгө оруулалтаар сумын төвийг төвлөрсөн халаалтын системд холбох, төрийн албан хаагч, залуу гэр бүлийг хямд үнэтэй орон сууцаар хангах бодлогын хүрээнд 12 айлын “Хаус” хорооллын барилгын ажлыг эхлүүлэх, Улаанбаатар хоттой сумын төвийг засмал замаар холбосон, шинэ сууршлийн бүс болон захын хороололд 472.0 сая төгрөгийн эрчим хүчний сайжруулалт хийх, иргэнд газар өмчлүүлэхэд сумын үндсэн иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж 4927 иргэнд 2,087.9 га газар өмчлүүлэх, “Эко тохилог хашаа” төслийг хэрэгжүүлэх, мах, сүүний үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулж МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг сумандаа боловсруулж үйлдвэрлэж байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг 95,4 хувь, сумын урианы жилийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 34 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас 28 арга хэмжээ 100 хувьтай 4 арга хэмжээ 90 хувьтай, 2 арга хэмжээ 70 хувьтай буюу нийт 97 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Алтанбулаг сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу ЕБС, сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа, Худалдаа үйлчилгээний байгууллагуудын албан татвар, төлбөр хураамж төлж байгаа эсэхэд, төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэрэгт хяналт хийж, ажлын дүгнэлт тайланг бичсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 758,818.1 мянган төгрөгөөр буюу 6,6 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	559,759.8	950,120.7	390,360.9
Авлага	714,500.5	291,843.3	(422,657.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	128,456.3	147,584.8	19,128.5
Үндсэн хөрөнгө	10,030,542.0	9,284,891.7	(745,650.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,433,258.6</b>	<b>10,674,440.5</b>	<b>(758,818.1)</b>
Өр төлбөр	958.5	254.6	(703.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,432,300.1	10,674,185.9	(758,114.2)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>11,433,258.6</b>	<b>10,674,440.5</b>	<b>(758,818.1)</b>

Эх сурвалж: Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 950,120.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 390,360.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 564,337.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 181,495.5 мянган төгрөгөөр, ОНХС-ийн үлдэгдэл 247,014.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 211,398.9 мянган төгрөгөөр, ХХС-ийн үлдэгдэл 108,955.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,584.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 291,843.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 422,657.2 мянган төгрөгөөр буурсан нь ОНХС-ийн авлага 266,637.5 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын авлага 137,000.0 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан нь шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 147,584.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 19,128.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ шувууны суулт 10,000.0 мянган төгрөг, ангилан ялгах хогийн сав 11,700.0 мянган төгрөг, модны суулгац 4,000.0 мянган төгрөг, өвс тэжээл 26,490.0 мянган төгрөгөөр орлого авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 300,789.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 30,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 52,069.6 мянган төгрөг, тавилга эд хогшил 14,560.0 төгрөгөөр нэмэгдэж, акталсан 14,422.0 мянган төгрөгөөр

буурсан байна. Тайлант онд 1,259,713.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл 745,650.4 мянган төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна..

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 10,674,185.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 758,114.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 950,120.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 390,360.9 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/ Бууралт /-/
Төрийн сангийн харилцах	518,460.01	936,938.51	418,478.50
Арилжааны банкны харилцах	41,299.75	13,182.20	(28,117.55)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	559,759.77	950,120.71	390,360.95

*Эх сурвалж: Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 950,120.71 мянган төгрөгийн 59,4 хувь буюу 564,337.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 26,0 хувь буюу 247,014.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн, 11,5 хувь буюу 108,955.8 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 1,8 хувь буюу 16,630.3 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлт барьцаа сан, 1,4 хувь буюу 13,117.0 мянган төгрөгийг эргэлтийн эмийн сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банкны үлдэгдэл 13,182.2 мянган төгрөгийн 0,5 хувь болох 65.2 мянган төгрөгийг “Төв Алтанбулаг тохижилт үйлчилгээ” ОНӨГ-ын үлдэгдэл, 13,117.0 мянган төгрөг буюу 99,5 хувийг эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт

*ЗДТГ нь 2,201.1 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, ХААН банкны 5724092427 дугаарын харилцах данс болон кассын 1,668.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгээгүй байна.*

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 313,843.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 826,294.7 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/ Бууралт /-/
Зээлийн хүүгийн авлага	5,219.88	3,956.91	(1,262.96)
Дансны авлага /ТӨҮГ/	257.05	1,214.74	957.69
Байгууллагаас авах авлага	425,637.50	22,000.00	(403,637.50)
Хувь хүмүүсээс авах авлага	283,386.10	264,671.68	(18,714.42)
<b>Авлагын дүн</b>	<b>714,500.52</b>	<b>291,843.34</b>	<b>(422,657.18)</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны эцсийн үлдэгдэл 291,843.3 мянган төгрөг болж буурсан нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажил үйлчилгээг хүлээн авсан, эрүүл мэндийн барилгын өргөтгөлийн ажлыг хүлээж авсантай холбоотой ЗДТГ-ын авлагын эхний үлдэгдлийн 150,000.0 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын 92,1 хувь буюу 268,628.6 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сан, 7,5 хувь буюу 22,000.0 мянган төгрөгийг ЗДТГ, 1,214.7 мянган төгрөгийг

эмийн эргэлтийн сангийн авлага байна. Хувь хүмүүсээс авах авлагын 100 хувь буюу 283,386.1 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

#### Аудитын илрүүлэлт

Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 268,628.6 мянган төгрөгийг тооцоо нийлж батлагаажуулаагүй, малчдын бүлэгтэй байгуулсан гэрээний үндсэн дээр Монголын мянганы сорилын сангийн хөрөнгөөр хийгдсэн худгийн ажлын зээлийн авлага 19,908.1 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 128,456.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 161,390.0 мянган төгрөгөөр буурсан байна.

#### **Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл**

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
Тусгай зориулалттай материал	31,699.63	53,038.07	21,338.44
Дуусаагүй үйлдвэрлэл	18,662.51	-	(18,662.51)
Аж ахуйн материал	73,094.14	89,546.71	16,452.57
Мал амьтад	5,000.00	5,000.00	-
<b>Бараа материалын дүн</b>	<b>128,456.28</b>	<b>147,584.78</b>	<b>19,128.50</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын эцсийн үлдэгдэл 128,456.3 мянган төгрөгийн 58,1 хувийг ЗДТГ, 24,7 хувийг эмийн эргэлтийн сан, 2,7 хувийг ИТХ, 14.5 хувийг ОНХС-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 148,584.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 19,128.5 мянган төгрөгөөр өссөн нь шувууны суулт 10,000.0 мянган төгрөг, ангилан ялгах хогийн сав 11,700.0 мянган төгрөг, модны суулгац 4,000.0 мянган төгрөг, өвс тэжээл 26,490.0 мянган төгрөгөөр орлого авсан нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

#### **Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /цэвэр дүн/**

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
Барилга, байгууламж, орон сууц	1,019,498.11	1,217,306.68	197,808.58
Авто-тээврийн хэрэгсэл	234,329.52	231,798.31	(2,531.21)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	81,343.84	105,012.90	23,669.06
Тавилга, аж ахуйн эд хогшил	13,973.45	23,503.84	9,530.38
Зам, гүүрийн байгууламж	8,424,995.98	7,384,030.18	(1,040,965.80)
Бусад үндсэн хөрөнгө	178,474.92	241,253.56	62,778.63
Ном	21,818.20	21,818.20	-
Бусад биет бус хөрөнгө	56,108.00	60,168.00	4,060.00
<b>Үндсэн хөрөнгийн дүн</b>	<b>10,030,542.01</b>	<b>9,284,891.66</b>	<b>(745,650.35)</b>

*Эх сурвалж: Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 13,999,924.4 мянган төгрөгийн 99,8 хувийг буюу 9,263,213.7 мянган төгрөгийг ЗДТГ, 4,077.3 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сан, 16,850.7

мянган төгрөгийг ИТХ, 750.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 300,789.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 30,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 28,339.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 14,422.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 1,258,266.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл 763,695.5 мянган төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 678,687.4 мянган төгрөгийн өртгөтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчилд албан шаардлага өгсөн.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 958.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,823.4 мянган төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл**

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
Ажилчидтай холбогдсон өглөг	228.47	124.60	(103.86)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	730.00	130.00	(600.00)
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>958.47</b>	<b>254.60</b>	<b>(703.86)</b>

Эх сурвалж: Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 254.6 мянган төгрөгөөр буурсан нь эмийн эргэлтийн сангийн өр төлбөр буурсантай холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 254.6 мянган төгрөгийн үлдэгдлийн 130.0 мянган төгрөг нь байгалийн нөхөн сэргээлт, барьцаа сангийн, 124.6 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн өглөг эзэлж байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 11,432,300.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,665,506.4 мянган төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо**

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	735,484.95	735,484.95	-
Өмнөх үеийн үр дүн	14,928,196.29	10,315,255.01	(4,612,941.27)
Тайлант үеийн үр дүн	(4,612,941.27)	(758,114.22)	3,854,827.05
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	381,560.15	381,560.15	-
<b>Цэвэр хөрөнгө, өмчийн дүн</b>	<b>11,432,300.11</b>	<b>10,674,185.89</b>	<b>(758,114.22)</b>

Эх сурвалж: Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 758,114.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Алтанбулаг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “сумын 2023 оны төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолоор 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 1,974,270.5 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,974,270.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Алтанбулаг сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн “Сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 259.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,233,505.6 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 2,033,505.6 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 200,000.0 мянган төгрөгөөр, нийт 2,233,505.6 мянган төгрөгийг тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,369,147.9 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 435,657.7 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 130,700.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 200,000.0 мянган төгрөг, бусад тусламжийн эх үүсвэрээс 98,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг орон нутгийн төсвийн орлогоос 1,415,055.3 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 424,751.5 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 122,082.8 мянган төгрөг, бусад тусламжийн эх үүсвэрээс 61,805.9 мянган төгрөгийг санхүүжүүлж, 45,181.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,786,712.4 мянган төгрөг буюу 80,0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардал 8,284.3 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 29,640.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1,656.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 9,072.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 300,022.5 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, хөрөнгийн зардал тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор хэмнэгдсэн байна.

#### Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал	109,053.20	105,718.59	3,334.61	96.9
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага үндсэн үйл ажиллагааны зардал	758,265.50	735,006.45	23,259.05	96.9
3	Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардал	217,262.00	217,261.19	0.81	100.0
4	Эрүүл мэндийн төвийн тогтмол зардал	34,567.20	34,240.83	326.37	99.1
5	Цэцэрлэгийн тогтмол зардал	51,844.30	51,787.38	56.92	99.9
6	Соёлын төвийн тогтмол зардал	140,655.70	124,364.04	16,291.66	88.4
7	Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардал	200,000.00	96,498.70	103,501.30	48.2
8	Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний зардал	721,857.70	421,835.22	300,022.48	58.4
	<b>Дүн</b>	<b>2,233,505.60</b>	<b>1,786,712.41</b>	<b>446,793.19</b>	<b>80.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв. түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 100,485.1 мянган төгрөг, ИТХ 24,459.7 мянган төгрөг нийт 124,944.8 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого. зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/ мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 99.4 %	109,053.20	105,718.59
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 6 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 99,6%	758,265.50	735,006.45
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл хүссэн иргэн, ААН-д зээл олгоно	2023 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100%	200,000.00	96,498.70
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Байр ашиглалттай холбоотой зардлагыг санхүүжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь	217,262.00	217,261.19
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Байр ашиглалттай холбоотой зардлагыг санхүүжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь	51,844.30	51,787.38
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Байр ашиглалттай холбоотой зардлагыг санхүүжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь	140,655.70	124,364.04
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Байр ашиглалттай холбоотой зардлагыг санхүүжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь	34,567.20	34,240.83
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 14 төслийг 604000,0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 9, мөнгийг нь дутуу шилжүүлсэн 3 ажил байна. Хэрэгжээгүй 2 ажил байна.	721,857.70	421,835.22
<b>Нийт дүн</b>					<b>2,233,505.60</b>	<b>1,786,712.41</b>

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 05/62 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 3,517,579.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 52,763.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 39,572.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 149 мэдээллээс 2023 оны хагс жилийн санхүүгийн тайлан болон аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 05/152 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

*Хүснэгт 10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	54,315.6	1	54,315.6	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>54,315.6</b>	<b>1</b>	<b>54,315.6</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, ОНХС-ийн үйл ажиллагааг авч үзэхээр шийдвэрлэв.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар илэрсэн 86,430.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

### **5.1 Албан шаардлага**

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 112,5 хувиар давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого 2,6-62,8 хувиар буюу 86,430.2 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга										
ЗДТГ	5	558,962.0	1	456.2	4	558,505.8	5	558,962.0		
Дүн	5	558,962.0	1	456.2	4	558,505.8	5	558,962.0		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Засаг дарга	1	86,430.2			1	86,430.2				
ЗДТГ	6	706,283.4	1	8,854.8	2	16,540.1	3	680,888.5		
ИТХ	1	2,525.3	1	2,525.3						
ХХС	2	288,532.6			2	288,532.6				
Дүн	6	1,083,771.5	2	11,380.1	5	288,532.6	3	680,888.5		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ОНХС	1	49,920.6						1	49,920.6	
Дүн	1	49,920.6						1	49,920.6	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	1	49,920.6						1	49,920.6	

### Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр		
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй	
		Санал дүгнэлт гаргах	Түүвэрт хамрагдах	Аудит хийгээгүй		Хязгаарлалттай	Сөрөг
Төсвийн шууд захирагч	2	1	1		1		
Орон нутгийн тусгай сан	4		4				
ОНӨААТҮГ	1		1				
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1			1		
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>2</b>	<b>6</b>		<b>2</b>		